



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар A/101

Баян-Өндөр сум

Г Комисс шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 6 дахь заалт, 3.1, 3.2 дугаар зүйлийн 1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/383, 2023 оны "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам батлах тухай" А/402 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын албын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, комиссын ажиллах журмыг гуравдугаар, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэгчийн бүрдүүлсэн баримт бичгийн бүрдэлийн хяналтын хуудас тавдугаар, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн сунгалт хийхэд бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлийн хяналтын хуудас зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын гишүүд, ажлын албад үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
TYP ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 11 сарын 24 өдрийн 11:01
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: -Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Орлогч дарга: -Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд :
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Хяналт шалгалтын хэлтсийн эрүүл ахуйн халдварт хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч
-Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн ажилтан

Нарийн бичгийн дарга:
хариуцсан -Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл ахлах мэргэжилтэн



Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 1.. сарын 1.. өдрийн 1101
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

9043446 2020030036

АЖЛЫН АЛБАНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын албаны дарга:

-Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан
ахлах мэргэжилтэн

Гишүүд:

- Хүний нөөцийн төлөвлөлт хангарт, мэргэжлийн үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
- Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал
зохиостой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
- Сувилахуй, хөнгөвчлөх тусlamж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн
- Эмнэлгийн дотоод халдварт хариусан мэргэжилтэн

OO